



**НИЙСЛЭЛИЙН
СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

**Г Улаанбаатар хотын аварга шалгаруулах
ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт
гимнастикийн тэмцээнийг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 2019 оны 04 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны "Спорт цогцолбор"-т зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 9.560.000 /есөн сая таван зуун жаран мянган/ төгрөгийг Нийслэлийн спортын хорооны биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа /-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны
дөрөвдүгээр сарын 10-ны өдрийн 1/26 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт
гимнастикийн тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 44 x 20.000 төг = 880.000 төг 44 x 15.000 төг = 660.000 төг 68 x 10.000 төг = 680.000 төг	2.220.000
2.	Багийн шагнал	1.800.000
3.	Шүүгчдийн ажлын зардал /16 хүн x 2 өдөр x 30.000 төг/	960.000
4.	Заал талбайн зардал	250.000
5.	Тайз, карказ, үзель	740.000
6.	Анонс,	300.000
7.	Медаль	2.490.000
8.	Цом, өргөмжлөл	800.000
Нийт дүн		9.560.000

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны
дөрөвдүгээр сарын 10-ны өдрийн А/16 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн
тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | А.Болдмаа |
| 2. Шүүгч | А.Болорцэцэг |
| 3. Шүүгч | Б.Бат-Отгон |
| 4. Шүүгч | Б.Оюун |
| 5. Шүүгч | Э.Энхтуяа |
| 6. Шүүгч | Ч.Отгонцэцэг |
| 7. Шүүгч | Р.Лхамсүрэн |
| 8. Шүүгч | Р.Ууганболор |
| 9. Шүүгч | С.Отгонбаатар |
| 10. Шүүгч | Э.Мөнх-Оргил |
| 11. Шүүгч | М.Цогзолмаа |
| 12. Шүүгч | У.Мягмарсүрэн |
| 13. Шүүгч | Б.Номин |
| 14. Шүүгч | У.Нарантуяа |
| 15. Шүүгч | Э.Оюун-Эрдэнэ |
| 16. Шүүгч | М.Сумъяадорж |